



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/052/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn
Сүхбаатар сум
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Батмөнх
Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Баасансүрэн
Утас: 7036-2442 Цахим хаяг: Baasansurens@audit.gov.mn

Энэхүү тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10-11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11-12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12-13
4. Аудитын тайлан	14-17
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14-15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. Аудитын илрүүлэлт	15
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Г СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН Г
ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА Т.ОДСҮРЭН ТАНАА

2025.02.25 № *СЭА-2025/ОСЭ/МӨ-ӨА-ТӨБ*
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын албан тушаалын зэрэглэл, цалингийн доод хэмжээнд өөрчлөлт орсноос шалтгаалж тус газрын цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардал өмнөх оноос 149,555.0 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 17,903.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Тус газар 2024 онд төрийн захиргааны 6, төрийн үйлчилгээний 2 зэрэг нийт 8 орон тоотой байхаар аймгийн ИТХ-аас баталснаас гүйцэтгэлээр төрийн захиргааны 6, төрийн үйлчилгээний 3 албан хаагчтайгаар буюу төрийн үйлчилгээний албан хаагчийн батлагдсан орон тоонд тусгагдаагүй “нярав-жолооч”-ийг томилон ажиллуулсан байна. Тусгайлсан албан тушаалын тодорхойлолтгүй нягтлан бодогч-хүний нөөцийн ажилтан, архив-бичиг хэргийн ажилтан, нярав-жолооч гэсэн нийт албан хаагчдын 33.3 хувьтай тэнцэх төрийн үйлчилгээний албан тушаалыг бие даан гүйцэтгүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 39 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 99.5 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,268,700.00	7,288,275.00
33	АВЛАГА	304,700.00	-
335	Бусад авлага	304,700.00	-
3351	Байгууллагаас авах авлага	304,700.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	3,964,000.00	7,288,275.00
354	Хангамжийн материал	3,964,000.00	7,288,275.00
35410	Бичиг хэргийн материал	518,000.00	989,375.00
35420	Аж ахуйн материал	1,616,000.00	3,565,000.00
35440	Түлш, шатах тослох материал	280,000.00	370,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,550,000.00	2,363,900.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	24,743,325.08	56,121,218.96
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	24,743,325.08	56,121,218.96
392	Биет хөрөнгө	24,743,325.08	51,996,218.96
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	31,798,900.00	57,894,700.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(16,069,241.48)	(19,325,379.32)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,100,600.00	18,695,600.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,086,933.44)	(5,268,701.72)
393	Биет бус хөрөнгө	-	4,125,000.00
39301	Программ хангамж	880,000.00	5,380,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(880,000.00)	(1,255,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	29,012,025.08	63,409,493.96
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	29,012,025.08	63,409,493.96
51	Засгийн газрын хувь оролцоо	29,012,025.08	63,409,493.96
512	Хуримтлагдсан үр дүн	29,012,025.08	63,409,493.96
51210	Өмнөх үеийн үр дүн	29,012,025.08	29,012,025.08
51220	Тайлант үеийн үр дүн	-	34,397,468.88
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	29,012,025.08	63,409,493.96

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	170,557,140.50	417,856,155.06
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,000.00	15,535,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	20,000.00	15,535,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,000.00	15,535,800.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	20,000.00	15,535,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	170,537,140.50	402,320,355.06
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	170,537,140.50	402,320,355.06
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	170,537,140.50	402,320,355.06

2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	158,970,231.25	382,666,019.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	158,970,231.25	382,666,019.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	157,970,231.25	355,646,532.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	117,455,838.48	267,010,859.43
210101	Үндсэн цалин	77,912,935.96	106,500,195.55
210102	Нэмэгдэл	29,519,811.94	130,127,044.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,812,857.14	11,440,000.00
210104	Урамшуулал	5,210,233.44	18,943,619.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,807,049.39	32,710,936.11
210201	Тэтгэврийн даатгал	10,039,584.04	23,438,759.54
210202	Тэтгэмжийн даатгал	1,164,224.07	2,812,263.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	830,969.48	1,379,693.30
210204	Ажилгүйдлийн даатгал	208,293.66	1,020,004.01
210205	Эрүүл мэндийн даатгал	2,563,978.14	4,060,215.88
2104	Хангамж, бараа материалын зардал	9,670,750.00	10,899,597.00
210401	Бичиг хэрэг	2,753,220.00	2,237,425.00
210402	Тээвэр, шатахуун	4,140,000.00	5,480,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,933,420.00	2,274,722.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	844,110.00	907,450.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	153,500.00	11,560,000.00
210604	Урсгал засвар	153,500.00	11,560,000.00
2107	Томилолт, зочны зардал	7,487,400.00	11,067,900.00
210702	Дотоод албан томилолт	7,487,400.00	11,067,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	904,500.00	4,626,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00	4,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	604,500.00	626,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,491,193.38	17,771,239.74
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,440,000.00	4,931,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,051,193.38	12,840,239.74
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00	27,019,487.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	27,019,487.52
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	7,424,687.52
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	19,594,800.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	11,586,909.25	35,190,135.26
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	792,666.38
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	792,666.38
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(792,666.38)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	11,586,909.25	34,397,468.88

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	170,537,140.50	402,320,355.06
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	170,537,140.50	402,320,355.06

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	170,537,140.50	402,320,355.06
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	170,537,140.50	402,320,355.06
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	155,491,140.50	372,699,355.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	155,491,140.50	372,699,355.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	154,491,140.50	345,679,867.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	117,410,241.11	267,010,859.43
210101	Үндсэн цалин	77,867,338.59	129,628,900.00
210102	Нэмэгдэл	29,519,811.94	106,899,415.94
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,812,857.14	11,538,924.49
210104	Урамшуулал	5,210,233.44	18,943,619.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,807,049.39	32,710,936.11
210201	Тэтгэврийн даатгал	10,039,584.04	23,419,412.77
210202	Тэтгэмжийн даатгал	1,164,224.07	2,755,225.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	830,969.48	1,387,144.49
210204	Ажилгүйдлийн даатгал	208,293.66	1,031,414.77
210205	Эрүүл мэндийн даатгал	2,563,978.14	4,117,739.08
2104	Хангамж, бараа материалын зардал	12,128,450.00	12,220,272.00
210401	Бичиг хэрэг	3,271,220.00	2,708,800.00
210402	Тээвэр, шатахуун	4,400,000.00	5,424,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,238,120.00	1,970,022.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,219,110.00	2,117,450.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	313,500.00	13,112,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	160,000.00	1,552,900.00
210604	Урсгал засвар	153,500.00	11,560,000.00
2107	Томилолт, зочны зардал	7,487,400.00	11,067,900.00
210702	Дотоод албан томилолт	7,487,400.00	11,067,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	904,500.00	4,626,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00	4,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	604,500.00	626,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,440,000.00	4,931,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,440,000.00	4,931,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00	27,019,487.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	27,019,487.52
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	7,424,687.52
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	19,594,800.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	15,046,000.00	29,621,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	15,046,000.00	29,621,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,046,000.00	29,621,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	15,046,000.00	29,621,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	15,046,000.00	29,621,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(15,046,000.00)	(29,621,000.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	16,159,208.18	00.00	16,159,208.18
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	16,159,208.18	00.00	16,159,208.18
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	408,094.91	00.00	408,094.91
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	29,012,025.08	00.00	29,012,025.08
D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	29,012,025.08	00.00	29,012,025.08
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	29,012,025.08	00.00	29,012,025.08
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	34,397,468.88	00.00	34,397,468.88
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	63,409,493.96	00.00	63,409,493.96

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	416,095,300.00	375,300,867.54	40,794,432.46	90.20
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	416,095,300.00	375,300,867.54	40,794,432.46	90.20
210	Бараа, үйлчилгээний зардал	416,095,300.00	375,300,867.54	40,794,432.46	90.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	287,960,700.00	267,010,859.43	20,949,840.57	92.72
210101	Үндсэн цалин	129,628,900.00	129,628,900.00	0.00	100.00
210102	Нэмэгдэл	125,706,200.00	106,899,415.94	18,806,784.06	85.04
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	14,448,000.00	11,538,924.49	2,909,075.51	79.87
210104	Урамшуулал	18,177,600.00	18,943,619.00	(766,019.00)	104.21
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,245,100.00	32,710,936.11	4,534,163.89	87.83

210201	Тэтгэврийн даатгал	25,326,700.00	23,419,412.77	1,907,287.23	92.47
210202	Тэтгэмжийн даатгал	2,979,600.00	2,755,225.00	224,375.00	92.47
210203	ҮОМШӨ ний даатгал	1,489,800.00	1,387,144.49	102,655.51	93.11
210204	Ажилгүйдлийн даатгал	1,489,800.00	1,031,414.77	458,385.23	69.23
210205	Эрүүл мэндийн даатгал	5,959,200.00	4,117,739.08	1,841,460.92	69.10
2104	Хангамж, бараа материалын зардал	19,078,000.00	12,220,272.00	6,857,728.00	64.05
210401	Бичиг хэрэг	5,187,600.00	2,708,800.00	2,478,800.00	52.22
210402	Тээвэр (шатахуун)	7,017,600.00	5,424,000.00	1,593,600.00	77.29
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	3,002,800.00	1,970,022.00	1,032,778.00	65.61
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	3,870,000.00	2,117,450.00	1,752,550.00	54.71
2106	Эд хогшил худалдан авах	39,102,100.00	38,233,900.00	868,200.00	97.78
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,900,000.00	19,758,900.00	141,100.00	99.29
210602	Тавилга	7,202,100.00	6,915,000.00	287,100.00	96.01
210604	Урсгал засвар	12,000,000.00	11,560,000.00	440,000.00	96.33
2107	Томилолт, зочны зардал	16,274,800.00	11,067,900.00	5,206,900.00	68.01
210702	Дотоод албан томилолт	16,274,800.00	11,067,900.00	5,206,900.00	68.01
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	11,054,600.00	9,126,000.00	1,928,600.00	82.55
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,000,000.00	8,500,000.00	1,500,000.00	85.00
210806	Мэдээллийн технологийн зардал	1,054,600.00	626,000.00	428,600.00	59.36
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	5,380,000.00	4,931,000.00	449,000.00	91.65
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,380,000.00	4,931,000.00	449,000.00	91.65
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	40,692,800.00	27,019,487.52	13,673,312.48	66.40
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	40,692,800.00	27,019,487.52	13,673,312.48	66.40
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,692,800.00	27,019,487.52	13,673,312.48	66.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,692,800.00	27,019,487.52	13,673,312.48	66.40
213208	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж	18,462,000.00	7,424,687.52	11,037,312.48	40.22
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	22,230,800.00	19,594,800.00	2,636,000.00	88.14
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	456,788,100.00	402,320,355.06	54,467,744.94	88.08
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	456,788,100.00	402,320,355.06	54,467,744.94	88.08
132001	Орон нутгийн төсвөөс	456,788,100.00	402,320,355.06	54,467,744.94	88.08
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	7.00	7.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	5.00	5.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	1.00	1.00	-	100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар нь “Санхүүгийн хяналт, дотоод аудитын хяналтын үр нөлөөг сайжруулах” гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/279 дүгээр захирамжаар баталсан “Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дүрэм”-ийн 5.1-д тус албаны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- *Хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, гэрээг мөрдөж байгаа байдал, хэрэгжилтийн хяналтыг байгууллагын дотоод хяналт болон засаглалд аудит хийх,*
- *Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, бүртгэл, зарцуулалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих,*
- *Эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр ашигтай байдалд аудит хийх,*
- *Төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа хөтөлбөр, төсөл, арга хэмжээний зарцуулалт, үр ашигтай байдалд хяналт тавих,*
- *Төсөв, санхүүгийн холбогдолтой хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журам, заавар, стандарт, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих,*
- *Төсвийн буюу төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагын өглөг, авлагын байдалд хяналт тавих,*
- *Тухайн байгууллагын орлогын төлөвлөлт, төвлөрүүлэлт, төсвийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих,*
- *Засгийн газрын тусгай зориулалтын сан, төсвөөс олгосон санхүүгийн тусламж дэмжлэг, эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглуулж байгаа төсвийн хөрөнгө, олон улсын байгууллага, гадаад орны Засгийн газар, байгууллага, иргэдээс олгосон зээл, өгсөн хандив, тусламж, тэдгээртэй адилтгах хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавих,*
- *Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашгийн байдалд хяналт тавих.*

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн албаны тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,*

- Сангийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/52 дугаар тушаалаар дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн баталсан гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсээс сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан төсвийн дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажил байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус газар нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагууд “Сэлэнгэ аймгийн төсөвт байгууллагууд дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 63,409.5 мянган төгрөг болж өмнөх оноос 34.397.5 мянган төгрөгөөр буюу 45.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	304.7	-	(304.7)
Бараа материал	3,964.0	7,288.3	3,324.3
Үндсэн хөрөнгө	24,743.3	56,121.2	31,377.9
Нийт хөрөнгө	29,012.0	63,409.5	34,397.5
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	29,012.0	63,409.5	34,397.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	29,012.0	63,409.5	34,397.5

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Өмнөх онд үүссэн интернэтийн үйлчилгээний 304.7 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан байна.
- Бараа материал дансны үлдэгдэл 7,288.0 мянган төгрөг болж 3,324.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 27,753.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 24,575.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 56,121.3 мянган төгрөг болж 31,377.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 29,621.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, ухаалаг дэлгэц, тавилга эд хогшил худалдан авсан, аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/60 дугаар захирамжаар 15,389.8 мянган төгрөгийн суурин компьютер, хэвлэгч зэрэг тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авч, аймгийн ИТХ-ын 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 158 дугаар тогтоолыг үндэслэн 9,820.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассан болон 12,840.2 мянган төгрөгийн элэгдлийг нэмж байгуулсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар нь 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 464,388.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг нийт 7,600.0 мянган төгрөгөөр бууруулж баталсан байна. Үүнд:

- Эд хогшил, урсгал засварын зардлыг 4,636.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 10,000.0 мянган төгрөг, ажил

олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардлыг 38,730.8 мянган төгрөг зэрэг нийт 53,367.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж,

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 37,864.0 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 3,483.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 19,620.0 мянган төгрөг зэрэг нийт 60,967.0 мянган төгрөгөөр бууруулж, 456,788.1 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 456,788.1 мянган төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 402,320.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 402,320.3 мянган төгрөг буюу 88.1 хувьтай тайлагнагдаж, 54,467.7 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 20,949.8 мянган төгрөгөөр, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 4,534.2 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 6,857.7 мянган төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардлыг 868.2 мянган төгрөгөөр, албан томилолтын зардлыг 5,206.9 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 1,928.6 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 449.0 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэгийг 13,673.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	416,095.3	375,300.9	40,794.4	90.2
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	40,692.8	27,019.5	13,673.3	66.4
	Нийт	456,788.1	402,320.4	54,467.7	88.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130051416 тоот дансанд тайлант онд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Баасансүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 158,970.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,589.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, тайлант оны батлагдсан төсвийг 54,467.7 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга,

нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар нь шилэн дансны цахим хуудагт мэдээлбэл зохих 28 төрлийн 168 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны 173 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 529.7 мянган төгрөгийн 2 зөрчилд өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	529.7	2	529.7	100
Нийт дүн	2	529.7	2	529.7	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой залруулсан алдаа гараагүй.

Аудитаар зөрчил¹ илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Нийт дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо
Нийт дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	-	-	-	-	-	-	-	-